

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 26

Номгон

Нэг. Байгууллагын зорилго, чиг үүрэг, бүтэц, орон тоо, үйл ажиллагаатай холбоотой товч танилцуулга

Зорилго

Орон нутгийн төсөвт байгууллагууд болон Төрийн өмчийн оролцоотой ОНӨҮГ-ын өмч, хөрөнгийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохицуулах.

1.1. Чиг үүрэг

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, үзлэг, тооллого зохион байгуулах, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт тавих, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх, компаний засаглалыг хэрэгжүүлэх ажлыг удирлага, зохицуулалтаар хангах, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, орон нутгийн өмчийн удирлагыг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өмчийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн удирлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

1.2. Бүтэц, орон тоо

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагийн тоог нэмэгдүүлэх “Худалдан авах ажиллагааны газар”-ыг Орон нутгийн өмчийн газраас салган бие даан ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/660 дугаар захирамжаар нийт 13 орон тоотойгоор батлуулж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс шинэ бүтцийн дагуу Газрын дарга Ц.Идэрмөнх, Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Долгорсүрэн, Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Мөнхзул, Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн А.Дорждулам, Хууль, хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Д.Төмөрбаатар, Нягтлан бодогч Л.Дуламсүрэн, Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав М.Пүрэвдулам, Жолооч Б.Зондуй, Харуул Д.Энхбаатар гэсэн 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
БҮТЭЦ ОРОН ТОО**



**ХОЁР. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БҮРТГЭЛЭЭР ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ,
ӨМЧИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ.**

2.1. Өмч хөрөнгөтэй холбогдон гарсан тогтоол шийдвэр

ИТХ-ын даргын захирамжаар:

Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар орон нутгийн өмчит

- ✚ 233 байгууллагын 31,6 тэрбум төгрөгийн хөрөнгөд эзэмшигч тогтоох,
- ✚ 15 байгууллагын 2,2 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх,
- ✚ 49 байгууллагын 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах,
- ✚ 40 байгууллагын /давхардсан тоогоор/ 8,1 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдах

тухай шийдвэр тус тус гаргуулсан.

✚ Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 50 дугаар захирамжаар Баянлиг сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Toyota Naice маркийн автомашиныг Баянлиг сумын ИТХ-д шилжүүлэх гэснийг, ИТХ-ын даргын 2024 оны 69 дүгээр захирамжаар Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газрыг дуудлага худалдаагаар худалдах гэснийг тус тус хүчингүй болгосон.

/Хүснэгтээр харуулбал/

№	Шийдвэрийн төрөл	Тогтол шийдвэрийн нэр	Байгууллагын тоо	Дүн
1	2	3	4	5
1	Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар	Эд хөрөнгөд эзэмшигч тогтоох	233	31,6 тэрбум
2		Эд хөрөнгийг актлах, данснаас хасах	49	2,5 тэрбум
3		Эд хөрөнгийг шилжүүлэх	15	2,2 тэрбум
4		Хөрөнгө худалдах, хувьчлах	40	8,1 тэрбум
5		Хүчингүй болсон	2	156 сая

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/95 дугаар тушаалаар орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл арга хэмжээний хүрээнд 1,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий малын зохиомол хээлтүүлгийн зөөврийн багаж, ачааны автомашинуудыг 17 сумдад хүлээлгэн өгсөн.

Аймгийн Засаг даргын 2024.04.30-ны өдрийн А/82 дугаар, 2024.05.30-ны өдрийн А/326 дугаар захирамжаар тус тус улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг хүлээн авах ажлын комисст ажиллаж, хөрөнгийг хүлээлгэн өгсөн.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/487 дугаар захирамжаар “Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж, сургуулийн өмнөх насны хүүхдийн шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи /ШИМТ/-ийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх сургалтын 949,8 сая төгрөгийн хэрэглэгдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны газарт хүлээлгэн өгөх ажлын хэсэгт ажиллаж хөрөнгийг бүртгэлд тусгуулж ажилласан.

2.2.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн “Захиргааны статистикийн мэдээлэл”-ийг хүлээн авч, нэгтгэх

2023 оны жилийн эцсийн тайлангаар орон нутгийн өмчит 264 байгууллагын (тэрбум төгрөгөөр)

- 1.Барилга, байгууламж-289,8
- 2.Машин тоног төхөөрөмж-47,9
- 3.Тээврийн хэрэгсэл-13,4
- 4.Тавилга, эд хогшил-13,8
- 5.Ном-1,0
- 6.Түүх соёлын дурсгалт зүйл-1,0
- 7.Дуусаагүй барилга-1,1
- 8.Бусад үндсэн хөрөнгө-36,6
- 9.Программ хангамж-1,0

10.Газар-20,7 нийт **426,3 тэрбум** төгрөгийн үндсэн хөрөнгө, 63,9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө тус тус нэгтгэн Төрийн өмчийн цахим системд оруулж, дүнг төсвийн шууд захирагч бүрээр Сангийн яамны “Э-тайлан” цахим системтэй тулган баталгаажуулж ТӨБЗГ-т хүлээлгэн өгсөн.

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчит байгууллагуудын
2016-2023 оны хөрөнгийн дүн**

/Тэрбум төгрөгөөр/



2.3. Хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнэ шинэчлэн тогтоох

Орон нутгийн өмчит 139 байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/130 тоот албан бичгээр элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож ирүүлэхийг мэдэгдсэн.

Тус албан бичгийн дагуу Орон нутгийн өмчийн газрын даргын А/14 дугаар тушаалаар орон нутгийн өмчит 6 байгууллагын 238 нэрийн 464 ширхэг 323,2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоож, дахин ашиглах зөвшөөрөл олгосон.

2.4. Орлого төвлөрүүлэлт

Тайлант онд уралдаант шалгаруулалтын хувьчлалын орлого 253,5 сая төгрөг, нээлттэй дуудлага худалдаагаар 2 үл хөдлөх хөрөнгө 12 хөдлөх хөрөнгийг худалдаж 134,7 сая төгрөг, түрээсийн орлого 4,2 сая төгрөг **нийт 392,4** сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

/Хүснэгтээр харуулбал/

№	Орлогын төрөл	Дүн /Төгрөгөөр/
1	2	3
1	Уралдаант шалгаруулалт	253,506,600
2	Нээлттэй дуудлага худалдаа	134,745,224
3	Түрээсийн орлого	4,200,000
	Нийт	392,451,824

ГУРАВ. ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ХЭРЭГЖИЛТ

Орон нутгийн өмчийн өмч эзэмшлийн гэрээг Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Долгорсүрэн, өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан ахлах Т.Мөнхзул, мэргэжилтэн

А.Дорждулам нар Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит 183 байгууллагын 2023 оны гэрээг дүгнэн ажилласан.

Баянцагаан, Богд сумдын төсөвт байгууллагуудын гэрээг аймгийн Засаг даргын нэрэмжит нэгдсэн шалгалтын ажилтай хамтатган дүгнэсэн.

Гэрээ дүгнэхэд тооллогоор илэрсэн бүртгэлгүй, суурь үнэлгээ зөрүүтэй газрын зөрчлийг арилгаагүй, акталж данснаас хассан, балансаас балансад шилжүүлсэн, дуудлагын худалдаагаар худалдсан тээврийн хэрэгслийг авто тээврийн нэгдсэн сангаас хасуулаагүй, ашиглалтгүй тээврийн хэрэгслийн өмнөх онуудын хуримтлагдсан татварыг төлж барагдуулаагүй, төсөвт байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө, тайлан гаргадаггүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдалтай байна. Дээрх нийтлэг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр 23 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж зөвлөмж өгч ажилласан.


ДӨРӨВ. УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГООР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

Газар

Аймгийн хэмжээнд 298 нэгж талбарын газар бүртгэлгүй, 117 нэгж талбарын газар суурь үнэлгээ зөрүүтэй байгаагаас жилийн эцсийн байдлаар суурь үнэлгээ зөрүүтэй **44** нэгж талбарын газар, бүртгэлгүй **123** нэгж талбарын газрын зөрчлийг арилгасан байна.



Тээврийн хэрэгсэл



Улсын үзлэг тооллогод орон нутгийн өмчит 173 байгууллагын 740 ширхэг 10,8 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгслээс 650 тээврийн хэрэгсэл зөчилгүй, 90 тээврийн хэрэгсэл зөрчилтэй байгаа бөгөөд 52 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулсан.

Мөн маргаантай Баян-Овоо сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй

27,5 сая төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хуралдааны 2023.12.05-ны өдрийн 17/65 дугаар тогтоолоор Цэвэр хот ОНӨААТҮГ-

т балансаас балансад шилжүүлсэн. Дутагдуулсан Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гинжин тракторыг хуулийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд шийдвэр гараагүй шалгагдаж байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 69 автомашин шинээр авснаас 69 тээврийн хэрэгсэлд дугаар олгуулж, нэр дээр шилжүүлэх албан бичиг гаргасан.

Улсын бүртгэл

Тооллогоор орон нутгийн өмчит 198 байгууллагын хуулийн этгээдийн хэлбэр хаягийн өөрчлөлтийг хийлгэхээс 133 байгууллага зөрчлийг арилгасан, 65 байгууллага мэдээллээ шинэчлээгүй байсныг зөрчлийг бүрэн арилгуулсан.

Дутагдсан хөрөнгө

Дутагдсан 17 нэрийн хөрөнгө байгаагаас 2 нэрийн 560,000 төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан, 1 нэрийн 1,4 сая төгрөгийн хөрөнгийг төлүүлсэн, Баянбулаг сумын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 97,8 сая төгрөгийн дизель моторын үнэ төлөгдсөн баримт олдсон, Гурванбулаг сумын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,1 сая төгрөгийн дизель моторыг 2023 оны 39 дүгээр Прокурорын тогтоолоор Шинэжинст сумын ЗДТГ-т шилжүүлсэн нь тогтоогдсон тул тус тус данснаас хассан, 8 сумын 11 ширхэг 315,2 сая төгрөгийн өртөг бүхий моторыг 2023 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэж, хуулийн байгууллагад шижүүлж, Аймгийн Засаг дарга-сумын Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээнд дутагдуулсан хөрөнгүүдийн зөрчлийг арилгаж, арга хэмжээ авч ажиллахаар оруулсан, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган авлагыг барагдуулах үүрэг даалгавар өгсөн.

№	Хуулийн этгээдийн нэр	Өмчийн нэр	Нийт үнэ	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн эсэх	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Баянхонгор аймгийн Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар	Мотор	9,809,845	Тийм	Авлагаар бүртгэсэн
2	Баянхонгор аймгийн Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар	Мотор	9,809,845	Тийм	Авлагаар бүртгэсэн
3	Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль	Утасгүй сүлжээний тоног төхөөрөмж	23,464,080		Давхар бүртгэлтэй болох эсэх нь шийдвэр хүлээгдэж байгаа
4	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар	Эрчим хүчний мотор	57,600,000	Тийм	Авлагаар бүртгэсэн
5	Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	ТООЗ-8 буу	289,120	-	Акталж, данснаас хассан.
6	Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	Хийн гар буу	271,350	-	Акталж, данснаас хассан.
1	2	3	4	5	6

7	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	Дизель мотор	12,157,500	-	Данснаас хассан.
8	Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар	Дизель мотор	12,628,305	Тийм	Авлагаар бүртгэсэн
9	Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	100мв дизел мотор	29,700,180	Тийм	Авлагаар бүртгэсэн
10	Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар	Японы 60 мотор	97,844,400	-	Данснаас хассан.
11	Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар	Дизел станц	57,600,000		Авлагаар бүртгэсэн
12	Баянхонгор аймгийн Заг сумын Засаг даргын Тамгын газар	DENYO-60 мотор	90,000,000	Тийм	Авлагаар бүртгэсэн
13	Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газар	Япон Улсын тусламж Мотор	12,000,000	Тийм	Авлагаар бүртгэсэн
14	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	цахилгаан үүсгүүр 2019	1,478,940	-	Төлсөн.
15	Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газар	Гинжин трактор	29,500,000	Тийм	Шийдвэрлэгдээгүй
16	Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын хүн эмнэлэг	Морь /550,000/	550,000		Шийдвэрлэгдээгүй
17	Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын хүн эмнэлэг	Хонь/ 2,732,500/	2,732,500		Шийдвэрлэгдээгүй
Нийт			447,436,065		

Нийт 8 нэрийн хөрөнгийн 279,1 сая төгрөгийн хөрөнгийг авлагаар бүртгүүлж, 4 нэрийн 110,5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасуулж, 1 нэрийн 1,4 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 4 нэрийн 56,2 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.

Маргаантай хөрөнгө

Маргаантай 9 нэрийн хөрөнгө байгаагаас 1 нэрийн 1,1 сая төгрөгийн хөрөнгийн асуудал шийдэгдсэн, 1 нэрийн 27,9 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг балансасад шилжүүлсэн, 7 нэрийн 112,5 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудад зөрчлийг арилгаж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг өгсөн.

№	Өмчийн төрөл	Өмчийн нэр	Хуулийн этгээдийн нэр	Нийт үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Барилга, байгууламж	Төвлөрсөн уурын зуух	Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар	1,440,659	Анхан шатны шүүхээс дээд шатны шүүхэд шилжсэн.
1	2	3	4	5	6

2	Дуусаагүй барилга	Тоглоомын талбай	Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар	7,400,000	Шүүхийн шийдвэрээр төлөх шийдвэр гарсан 1,0 сая төгрөгийг төлсөн.
3	Тээврийн хэрэгсэл	Хот тохижилтын машин	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	31,000,000	Шийдвэрлэгдээгүй
4	Газар	3 р багийн төвийн газар	Монгол Улсын арслан П.Аюушийн нэрэмжит Биеийн тамир спортын газар	27,538,000	Шийдвэрлэгдээгүй
5	Машин, Тоног төхөөрөмж	Яамаха пүлт	Галуут сумын Соёлын төв	1,180,000	Шийдвэрлэгдсэн.
6	Газар	Боловсролын байгууллага	Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль	3,622,000	Шийдвэрлэгдээгүй
7	Газар	Шаргалжуут тосгоны албан конторын барилгын газар	Баянхонгор сумын Шаргалжуут тосгон	2,400,000	Шийдвэрлэгдээгүй
8	Барилга, байгууламж	замын цагдаагийн хяналтын байр	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	39,130,000	Шийдвэрлэгдээгүй
9	Тээврийн хэрэгсэл	микробус	Баян-Овоо сумын Соёлын төв	27,500,000	Шийдвэрлэгдсэн.
Нийт				141,210,659	

ТАВ.КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Орон нутгийн өмчит Чандмань Баянхонгор ХК, Баянхонгор Эрчим хүч ЦТХХК, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК, Ингэн эрдэнэ ОНӨААТҮГазар, Жаргалтай амьдрал СНСЗТөв ОНӨААТҮГазар, Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар, Цэвэр хот ААТҮГазар, Баян Өсөх агро ОНӨААТҮГазрын хувийн хэргийн нэгжийг бүрдүүлсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран ТӨБЗГазрын Төрийн өмчийн удирдлага, төлөөллийн албаны В.Дарханбаатар даргаар ахлуулсан ажлын хэсэг Баянхонгор аймагт 2024 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр ОНӨКомпани, ОНӨААТҮГазрын удирдлага болон санхүүгийн ажилтнууд, Орон нутгийн өмчийн газрын нийт 26 албан хаагчдад Компанийн засаглалын мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Сургалтын хүрээнд, Баянхонгор аймгийн ОНӨмчит 6 компани, ОНӨААТҮГазрын Компанийн засаглалын нөхцөл байдалтай танилцан санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгсөн.

ЗУРГАА.ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны А/218 дугаар захирамжийн дагуу нэгдсэн шалгалтаар Богд, Баянцагаан сумын 12 төсөвт байгууллагын 17,2 тэрбум төгрөгийн хөрөнгийг нүд үзэн тоолж, 87,8 сая төгрөгийн хөрөнгийн зөрчил илэрсэн. Шалгалтын мөрөөр зөрчлийг яаралтай арилгах албан бичгийг сумын Засаг дарга, Тамгын газар, Соёлын төвүүдэд 21 заалт бүхий зөвлөмжөөр хугацаатай албан бичиг хүргүүлсэн. Зөрчлийг хэрхэн арилгах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн. Орон нутгийн өмчийн газрын даргын А/161, А/269 тоот албан бичгээр Санхүү төрийн сангийн хэлтэст ажлын тайланг хүргүүлсэн.

Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хөрөнгөд хяналтын тооллогыг хийсэн. Тоологын мөрөөр эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 7 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг албан бичгээр ирүүлэх хугацаатай үүрэг өгч ажилласан. Тооллолын ажлын тайланг ОНӨГазрын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.

Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Соёл, урлагын газарт 2024.05.30-ны өдөр төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тооллогыг хийж ажиллаа. Соёл, урлагийн газрын 72 сая төгрөгийн хөрөнгийг нэг бүрчлэн тооллого хийж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө тайлан, тооллогын тайлантай танилцсан. 2023 оны хагас жилийн тооллого хийгээгүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө, тайлан байхгүй, 1 ширхэг принтер, 1 ширхэг шар модон ширээ бүртгэлгүй зэрэг зөрчил илэрсэнийг ОНӨГазрын даргад илтгэх хуудсаар танилцуулж бүртгэлд тусгуулсан. Тоологын мөрөөр эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 7 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг албан бичгээр ирүүлэх хугацаатай үүрэг өгч хэрэгжилт хангасан болно.

Газрын даргын 2024 оны 06 сарын 10-ны өдрийн аймгийн Цагдаагийн газрын эд хөрөнгөд иж бүрэн хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу шалгалтыг хэрэгжүүлж ажилласан. Тоологын мөрөөр эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 8 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг албан бичгээр ирүүлэх хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан. Хяналт шалгалтын тайланг илтгэх хуудсаар танилцуулж бүртгэлд тусгуулсан.

Газрын даргын 2024 оны 11 сарын 05-ны өдрийн Баянхонгор Тохжилт үйлчилгээ ААТҮГазрын эд хөрөнгөд хяналтын тооллого хийх тухай” удирдамжийн дагуу шалгалтыг хэрэгжүүлж ажилласан Тоологын мөрөөр эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж,

зөрчлийг давтан гаргахгүй байх 3 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг албан бичгээр ирүүлэх хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан. болно. Хяналт шалгалтын тайланг илтгэх хуудсаар танилцуулж бүртгэлд тусгуулсан.

Хяналтад авсан Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Бодлогын баримт бичгийн хэрэгжилтүүдийн <http://bayankhongor.igovernment.mn/home/> хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд хэрэгжилт тайлагнах цаглаврын дагуу заасан хугацаанд бүрэн тайлагнан ажиллалаа.